



ҮНДЭСНИЙ АУДИТЫН  
ГАЗРЫН ХАРЬЯА  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032-3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.ГАНБОЛД-д

2017.01.16 № 108  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Өвөрхангай аймгийн ЗДТГазрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн шууд захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн шууд захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Төсвийн шууд захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өвөрхангай аймгийн ЗДТГазрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



*L. Lamaachin*

Л.ЛАМААЧИН



## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор  
Л. Ламаачин  
Утас: 70323253  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Ц. Отгонням  
Утас: 70323833  
Цахим хаяг:

Аудитор: С. Шийлэгмаа  
Шинжээч: Ч. Гантулга  
Утас: 70323833  
Цахим хаяг:

### Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1  
Мөнгөн хөрөнгө 2

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

Асуудал 1  
Цалингийн зардал 3

**Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:**

Асуудал 1  
Бараа материал 3

2017 оны 03-р сарын 15-ны өдөр

## **Менежментийн захидал**

Аймгийн Аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Аймгийн ЗДТГазарт зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Аймгийн ЗДТГазрын нягтлан бодогч О. Цэрэнчимэд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ААГ-ын ажиглалт**

1. Жилийн эцсийн тооллогоор кассанд байгаа 6495,7 мянган төгрөгийг тооллоогүй байгаа нь НББ-ын тухай хуулийн 12.2.1 заалтыг зөрчсөн байна.
2. Цайны газрын түрээсийн орлогыг гэрээний дагуу сар бүр төлөөгүй, жилийн нийт дүнгээр буюу төрийн сангийн гүйлгээ хаасны дараа кассанд бэлнээр 2016 оны 12 сарын 26 нд 5900,0 мянган төгрөг тушаасныг зарцуулсан байна.

**Эрсдэлүүд**

Дотоод хяналт сулрах. НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын журам зөрчигдөх

**ААГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах.

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 2.6 "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг мөнгөн кассаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана." гэсэн тушаалын заалтуудыг мөрдөж ажиллах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**ААГ-ын ажиглалт**

Цалингийн зардлаас 66,8 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах

**ААГ-ын зөвлөмж**

Зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулийн 7.7 дахь заалтыг мөрдөх зөвлөмж өгөв

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**ААГ-ын ажиглалт**

1. Бараа материалын тайланд гарын үсэг зурагдаагүй, тамга тэмдэггүй баримт байна. Энэ нь Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар ажил гүйлгээг хийж байх.
2. Жолоочын шатахуун зарцуулалттай холбоотой замын хуудас, явсан км болон норм спидометрын заалт бичигдээгүй хангалтгүй хөтөлсөн байна.

**Эрсдэлүүд**

Дотоод хяналт сулрах.



**ААГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Л. ЛАМААЧИН  
АУДИТЫН МЕНЕЖЕР  Ц. ОТГОННЯМ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  
ШИНЖЭЭЧ



С. ШИЙЛЭГМАА  
Ч. ГАНТУЛГА

ОГНОО: 2017.03.15

